



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/07/НА-СТА-ОНӨ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Болдбаатар Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	7
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.2 Материаллаг байдал	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4.5.1 Завсрын аудитын талаар	10
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Албан шаардлага	11
5.2 Зөвлөмж	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ж.СҮРЭНХҮҮ ТАНАА

2023.03.22 № 163
танай _____ - ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээр Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/51 захирамжийн дагуу 65,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч байгууллагын урсгал засвар үйлчилгээнд 37,390.0 мянган төгрөг, эд хогшил, хангамжийн материалд 27,610.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зориулан иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 137,900.0 мянган төгрөгийн хандив өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,983,100.06	101,934,419.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,195,019.58	169,833.51
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,076,850.00	54,538.00
31110	Төгрөг	3,076,850.00	54,538.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	118,169.58	115,295.51
31210	Төгрөг	118,169.58	115,295.51
31213	Арилжааны банк дахь харилцах	118,169.58	115,295.51
33	АВЛАГА	45,605,322.00	44,407,322.00
33500	Бусад авлага	45,605,322.00	44,407,322.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	45,605,322.00	44,407,322.00
35	БАРАА МАТЕРИАЛ	35,182,758.48	57,357,264.48
35400	Хангамжийн материал	35,182,758.48	57,357,264.48
35420	Аж ахуйн материал	35,182,758.48	57,357,264.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,498,144.55	51,640,348.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,498,144.55	51,640,348.12
39200	Биет хөрөнгө	15,498,144.55	51,640,348.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000.00	17,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,750,000.00	-12,237,500.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	32,422,045.32	24,030,189.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,678,230.77	-11,011,396.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	213,454,524.86	213,521,761.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-204,950,194.86	-180,162,705.44
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	99,481,244.61	153,574,768.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,402,070.67	71,322,292.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,402,070.67	71,322,292.17
41300	Өглөг	44,402,070.67	55,953,652.17
41360	Бусад өглөг	44,402,070.67	55,953,652.17
41361	Байгууллагад төлөх өглөг	16,062,825.00	33,581,850.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,424,900.00	0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	22,873,170.90	19,692,749.43
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	3,041,174.77	2,679,052.74
41400	Урьдчилж орсон орлого	0	15,368,640.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	0	15,368,640.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	55,079,173.94	82,252,475.94
51	Засгийн газрын хувь оролцоо	55,079,173.94	82,252,475.94
51100	Засгийн газрын оруулсан капитал	329,690,240.18	329,690,240.18
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	329,690,240.18	329,690,240.18
51200	Хуримтлагдсан үр дүн	-274,611,066.24	-247,437,764.24
51210	Өмнөх үеийн үр дүн	-254,507,027.31	-274,611,066.24
51220	Тайлант үеийн үр дүн	-20,104,038.93	27,173,302.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	99,481,244.61	153,574,768.11

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	367,249,073.00	657,258,399.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	367,249,073.00	657,258,399.80
120	Нийтлэг татварын бус орлого	367,249,073.00	657,258,399.80
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	367,249,073.00	657,258,399.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	387,353,111.93	628,464,724.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,353,111.93	628,464,724.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,353,111.93	628,464,724.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	387,353,111.93	628,464,724.48
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	359,256,747.30	400,589,783.40
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	0	161,055.31
210813	Бусад зардал /ТӨҮГ/	28,096,364.63	224,694,630.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0	3,019,255.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-20,104,038.93	28,793,675.32
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	1,620,373.32
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	1,620,373.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-20,104,038.93	27,173,302.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	329,690,240.18	-252,131,687.31	77,558,552.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	-2,375,340.00	-2,375,340.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	329,690,240.18	-254,507,027.31	75,183,212.87
4	Тайлант үеийн үр дүн	0	-20,104,038.93	-20,104,038.93
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	329,690,240.18	-274,611,066.24	55,079,173.94
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	329,690,240.18	-274,611,066.24	55,079,173.94
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	329,690,240.18	-274,611,066.24	55,079,173.94
9	Тайлант үеийн үр дүн	0	27,173,302.00	27,173,302.00
10	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	329,690,240.18	-247,437,764.24	82,252,475.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	372,611,225.00	657,654,376.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	372,611,225.00	657,654,376.00
120	Нийтлэг татварын бус орлого	372,611,225.00	657,654,376.00
120009	Бусад орлого	9,675,602.00	263,330,184.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	29,457,150.00	97,245,036.00
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	333,478,473.00	297,079,156.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	369,085,596.88	648,869,562.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,085,596.88	648,869,562.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,085,596.88	648,869,562.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,344,236.74	237,552,513.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	214,344,236.74	237,552,513.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,243,566.31	61,849,518.40
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	73,243,566.31	61,849,518.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,922,457.83	4,223,461.23
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	7,922,457.83	4,223,461.23
2104	Хангамж, бараа материалын зардал	53,436,490.00	197,227,215.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	1,505,300.00	25,811,310.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	51,931,190.00	171,415,905.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,138,846.00	148,016,854.44
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	12,215,971.00	28,521,134.44
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	7,922,875.00	119,495,720.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,525,628.12	8,784,813.93
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	550,000.00	11,810,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	550,000.00	11,810,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	550,000.00	11,810,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	550,000.00	11,810,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-550,000.00	-11,810,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,975,628.12	-3,025,186.07
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	219,391.46	3,195,019.58
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,195,019.58	169,833.51

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн зорилго нь “Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, тамгын газрын шаардлагад нийцсэн тохилог орчинд шуурхай үйлчилгээг чанартай хүргэхэд бүх талын дэмжлэг үзүүлж төсвийн зардлыг хөнгөвчлөх таатай нөхцөлийг бүрдүүлж ажиллах явдал юм” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төр захиргааны байгууллагад үзүүлэх үйлчилгээ, зочид буудлыг үйлчилгээ явуулах статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ статустайгаар орон нутгийн 100 хувийн өмчлөлтэй, Баруун-Урт суманд харьяалагдаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Засаг дарга болон засгийн ордонд ажилладаг төрийн албан хаагчдын шаардлагад нийцсэн нийтлэг үйлчилгээг явуулж, тэдгээрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хангалт хийх.
- Хурлын заалны зохион байгуулалт, лед дэлгэц болон урсдаг самбарын үйлчилгээ, ЗДТГазрын албан хаагчдын интернэт сүлжээ компьютерын засвар үйлчилгээ, техникийн сайжруулалт хийх.
- Засгийн ордны гадна болон дотор талын цэвэрлэгээ үйлчилгээ, өрөө тасалгааны тохижилт, цахилгаан дулаан, цэвэр бохир ус, барилгын ба сантехникийн урсгал засвар, харуул хамгаалалт, хувцасны өлгүүрийн үйлчилгээ, галын аюулгүй байдлын үйлчилгээ зэргийг хариуцаж түүнийхээ үр дүнгээр үйлчлүүлэгчээс хөлс авах.
- Авто машины жолооч, шуудан холбооны үйлчилгээгээр хангах. Засгийн ордонд ажилладаг төрийн албан хаагчдын шаардлагад нийцсэн нийтлэг үйлчилгээг явуулж, аж ахуйн ажлыг эрхэлж, тэдгээрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах нөхцөлийг хангах үүрэгтэйгээр ажиллаж байна.
- Засгийн ордны барилга, гадна ба дотор талын тохижилт, засвар үйлчилгээтэй холбоотой асуудлаар үйлчлүүлэгч газруудтай хамтран ярилцаж тодорхой асуудлыг удирдлагад танилцуулж төлөвлөн хэрэгжүүлэх.
- Аймгийн гадаад харилцаа хамтын ажиллагааны шугамаар ирсэн зочид төлөөлөгчдийг ажиллах нөхцөл байр, хоол зэрэг үйлчилгээг хариуцан зохион байгуулах.
- Ёслол хүндэтгэлийн чанартай үйл ажиллагаа түүнд зориулагдсан үйлчилгээг зохион байгуулах.
- ЗДТГазрын ажилчдын эрүүл аюулгүй байдлыг хангаж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчилгээгээр ханган ажилладаг бөгөөд үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад санал санаачилгатай ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 912,068.8 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,195.0	169.8	-3,025.2
Авлага	45,605.3	44,407.3	-1,198.0
Бараа материал	35,182.8	57,357.3	22,174.5
Үндсэн хөрөнгө	15,498.1	51,640.3	36,142.2
Нийт хөрөнгө	99,481.2	153,574.7	54,093.5
Өр төлбөр	44,402.0	71,322.3	26,920.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	55,079.2	82,252.4	27,173.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	99,481.2	153,574.7	54,093.5

Харилцах дансны үлдэгдэл 169.8 мянган төгрөг болж 3,025.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэлд 44,407.3 мянган төгрөг болж 1,198.0 мянган төгрөгөөр буурсан байна. Авлагын үлдэгдлийн 37,001.6 мянган төгрөг буюу 83.3 хувийг Мөнгөнчимэгтэй холбоотой шүүхийн шийдвэрээр шийдвэрлэгдсэн авлага байна.

Бараа материалын үлдэгдэл 57,357.3 мянган төгрөг болж 22,174.5 мянган төгрөгөөр өссөн нь буудлын цагаан хэрэгсэл, хөнжил, гудасыг шинэчлэн худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үнэ төлбөргүй буюу хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон 15,368.6 мянга, худалдан авсан 34,343.9 мянга, нийт 49,712.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 66,537.2 мянган төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 383 дугаар албан бичгийн дагуу акталж, хөрөнгө элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 71,322.3 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 26,920.3 мянган төгрөгөөр өссөн нь засварын материалын үнэ, хаоат-ын өглөг нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 400,589.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,008.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,206.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд зардлууд 3,699.0 мянган төгрөгөөр буурсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 орлогын, 26 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	8,200.0	2	8,200.0	100
Зөвлөмж	4	415,400.0	3	305,200.0	73.5
Нийт дүн	6	423,600.0	4	313,400.0	

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30.6 сая төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 30.6 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

- Худалдаж авсан 9.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй
- Бараа материалын тайланд 20.7 сая төгрөгийн барилгын материалыг бөөн дүнгээр орлого авсан.
- Үндсэн хөрөнгийн 0.5 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсон

Аудитаар нийт 64.5 сая төгрөгийн зөрчил³ илэрснээс, 57.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 7.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Илрүүлэлт

Тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээнээс нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон дэлгэрэнгүй хураангуй бүртгэлийн хөтлөлтийг түүвэрлэн шалгахад бүрдэл дутуу, анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Тухайлбал: Аймгийн 80 жилийн ойн морины бай-30. 0 сая төгрөг, сандлын түрээсийн хөлс-7.0 сая төгрөг, хавтан суулгасан ажлын хөлс 20.0 сая төгрөг

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д / аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/, 13 дугаар зүйлийн 13.1 /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7 /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;/ -д заасан заалт болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Илрүүлэлт

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 орлогын, 26 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5.2 Зөвлөмж

1. Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жолоочийн замын хуудсанд спидометрийн заалтыг бөглөөгүй, гарын үсгээр баталгаажаагүй, холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтлөөгүй, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй, тээвэр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй зэрэг зөрчил илэрлээ.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7 /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;/ -д заасан заалт болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шатахууны зардалд тавих хяналтыг сайжруулж, шатахууны орлого, зарлагын гүйлгээг холбогдох анхан шатны баримтаар баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах ажлыг зохион байгуулах.

2. Цахим худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цахим дэлгүүрт байршсан зөөврийн болон суурин компьютерыг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 2.6 сая төгрөгөөр худалдан авсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрт байгаа бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын дансаар дамжуулалгүй 4,887.9 мянган төгрөгийн шатах тослох материалын орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримтаар баримтжуулалгүй, авсан мөнгөн дүнгээр шууд зардал болгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д / аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/, 13 дугаар зүйлийн 13.1 /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.4- д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.7 /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;/ - д заасан заалт болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг тооцооны дансанд дамжуулан бүртгэж, орлого, зарлагын баримтыг үндэслэн тооцоог хийж, тайлагнаж, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй	1	9,380.0	1	9,380.0	-	-	1	9,380.0	-	-	-	-
Барилгын материалыг бөөн дүнгээр орлого авсан.	1	20,669.6	-	-	1	20,669.6	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцсон	1	531.4	-	-	1	531.4	-	-	-	-	-	-
Дүн	3	30,581.0	1	9,380.0	2	21,201.0	1	9,380.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
											Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жолоочийн шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Бүрдэл дутуу, анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.	1	57,000.0	-	-	1	57,000.0	-	-	-	-	-	-
Бараа материалыг авсан мөнгөн дүнгээр шууд зардал болгосон байна.	1	4,887.9	-	-	-	-	1	4,887.9	-	-	-	-
Дүн	3	61,887.9			1	57,000.0	2	4,887.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 орлогын, 26 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим дэлгүүрт байршсан барааг авалгүйгээр бусад этгээдээс худалдан авсан.	1	2,550.0	-	-	-	-	1	2,550.0
Дүн	1	2,550.0	-	-	-	-	1	2,550.0
Нийт дүн	2	2,550.0					1	2,550.0